



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ



ГАЗАРЗҮЙ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад хийж гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд харандаагаар зааврын дагуу будаарай.

1. Монгол орон нь тивд, өргөрөгийн 41°35' -аас өргөрөгийн 52°09' хооронд оршдог.



- A. Ази, хойд, өмнөд
- B. Ази, өмнөд, өмнөд
- C. Ази, хойд, хойд
- D. Ази, өмнөд, хойд

2. Дараах хотуудын алинд нь түрүүлж нар мандах вэ?

- A. Дархан (ЗУ105°)
- B. Ховд (ЗУ91°)
- C. Чойбалсан (ЗУ115°)
- D. Өлгий (ЗУ89°)

3. Монгол улсын хилийн боомтуудын зургийг ажиглан БНХАУ-тай хиллэх **олон улсын түр үйл ажиллагаа** явуулж буй боомтыг сонгоорой.

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН БООМТУУД




- A. Байтаг
- B. Даян
- C. Баянхошуу
- D. Сүмбэр

4. Монгол орны уулсын хамгийн том мужийг сонгоорой.

- A. Их Хянганы нуруу
- B. Алтайн уулсын их муж
- C. Хангайн нурууны их муж
- D. Хэнтэйн уулсын их муж

5. Доорх таних тэмдгийг ажиглан цаг агаарын ямар ямар үзүүлэлтийг дүрсэлсэн байгааг тодорхойлоорой.



- A. Тунадас, температур, үлшилт
- B. Шүүдэр цэгийн температур, салхи
- C. Үлшилт, даралт, салхины чиглэл
- D. Даралт, салхины хурд, тунадас

6. Манай оронд зундаа агаарын даралт, температур бөгөөд ноёрхоно.
А. бага, их, циклон
В. их, бага, эсрэг циклон
С. бага, бага, эсрэг циклон
D. их, их, циклон
7. Гэгээн нуур нь Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутагт орших бөгөөд Завхан голын Улаан Боомын хавцалд 50 м өндөр, 75 м өргөн, 190 м урт боомт байгуулж голын усыг хуримтлуулснаас үүссэн. Уг нуурын хонхрын гарал үүслийг сонгоорой.
А. галт уулын гаралтай
В. салхин хуримтлалын гаралтай
С. мөстлөгийн гаралтай
D. хүний үйл ажиллагааны гаралтай
8. Монгол орны уулархаг хэсгээр тархсан хүрэн хөрсөнд тарих боломжтой жимсний төрлийг сонгоорой.



А. жүрж



В. тарвас




С. үхрийн нүд




D. алим

9. Газарзүйн зурагт Монгол орныг дүрслэхэд огтолсон конус тусгагаар Φ_1 - Φ_2 өргөргийн дагуу гажилтгүй зурагддаг. Монгол орны хойд хэсгээр орших аймгуудын гажилтгүй зурагдах өргөргийг сонгоорой.




- A. ХӨ40°
B. ХӨ45°
C. ХӨ52°
D. ХӨ49°

10. Зургаас Хангайн нуруу болон Хөвсгөлийн уулсын оргилуудыг тодорхойлж, хоёр оргилын өндрийн зөрүүг тооцоолсон хувилбарыг сонгоорой.



- A. 530 м
B. 883 м
C. 353 м
D. 691 м


11. Стратегийн ач холбогдол бүхий нүүрсний ордуудыг зөв нэрлэсэн хэсгийг сонгоно уу.



А. Гурванбулаг – Мардай – Дорнод
 С. Бороо – Төмөртэй – Гацуурт

В. Оюутолгой – Цагаан суварга – Эрдэнэт
 Д. Нарийн сухайт – Багануур – Таван толгой

12. Дорноговь аймгийн 2023 оны 11 сарын температур болон тунадасны хэмжээг зурагт харуулжээ. Тунадас болон агаарын температурын хамаарлыг оновчтой тодорхойлсон хувилбарыг сонгоорой.




- A. Агаарын температур дулаан болох тусам чийгшил ихсэж тунадасны хэмжээ нэмэгдсэн байна.
- B. Агаарын температур буурахад харьцангуй чийг нэмэгдэн тунадас их орох нөхцөл бүрдсэн.
- C. Өвлийн улиралд агаарын үнэмлэхүй чийг их байх ба температур нэмэгдэхэд орсон тунадасны нийлбэр өндөр байна.
- D. Хөрсний гадаргын дундаж температур нэмэгдэхэд тунадас ихсэж, температур буурахад тунадасны хэмжээ багасаж байна.

13. Монголчуудын тэнгэрийн байдлыг шинжих уламжлалт аргуудыг зөв харгалзуулаарай.

1	Тэнгэр муудах шинж	А	Намар од их гялалзаж, тод харагдах
2	Улирал хатуу болох шинж	Б	Бороо орж байхад адуу шилгээх
3	Тэнгэр сайхан байх шинж	В	Нар, сар хүрээтэх
4	Улирал сайхан болох шинж	Г	Үхэр оготно хөөгөө эрт хураах


- A. 1B,2Г,3B,4A B. 1A,2B,3B,4Г C. 1Г,2B,3A,4B D. 1B,2B,3Г,4A

14. Монгол орны томоохон голуудын зургийг ашиглан Хойд мөсөн далайн ай савд багтах голуудыг тодорхойлоорой.



- А. Хэрлэн, Туул, Онон, Халх
 В. Эг, Орхон, Сэлэнгэ, Туул
 С. Тэс, Идэр, Завхан, Сэлэнгэ
 D. Орхон, Тэс, Идэр, Завхан

15. Хөрсийг ширхгийн бүрдлээр нь хүнд шавар, шавранцар, хөнгөн шавранцар, элсэнцэр гэхчлэн ангилдаг. Диаграммаар ямар төрлийн хөрсний бүрдлийг илэрхийлсэн байгааг сонгоорой.




- А. элсэрхэг хөрс
 В. хөнгөн шавранцар хөрс
 С. шаварлаг хөрс
 D. тоосорхог хөрс

16. 2024 оны 1 дүгээр сарын 21-нд Улаанбаатар хотод нар 08 цаг 31 минутад мандаж, орой 17 цаг 36 минутад жаргасан байна. Улаанбаатар хотод үд дунд хэдэн цагт болсныг тооцоолж олоорой.




- А. 4 цаг 35 минут
 В. 9 цаг 05 минут
 С. 13 цаг 06 минут
 D. 13 цаг 40 минут

17. Хэрлэн голын мэдээллийг ашиглан голын уналыг тооцоолж олоорой.



- А. 993 м
 В. 257 м
 С. 2375 м
 D. 1125 м


18. Монгол орны 2016 – 2020 оны сар бүрийн агаарын дундаж температурын үзүүлэлтийг ажиглан зөв тодорхойлсон хариултыг сонгоорой.



- A. Сүүлийн 5 жилийг харьцуулахад 2020 оны 4 дүгээр сар хамгийн дулаан сар болж өнгөрсөн байна.
- B. 2016 оноос хойш бүх саруудад агаарын температур тогтмол дулаан болж өнгөрсөн байна.
- C. Сүүлийн 5 жилийг харьцуулахад 2019 оны зуны сарууд хамгийн дулаан болж өнгөрсөн байна.
- D. 2018 он болон 2020 онд өвлийн саруудад хамгийн хүйтэн болж өнгөрсөн байна.

Дараах мэдээллийг ашиглан 19, 20 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.

Японы эрдэмтэд Монголын ШУА-ын Палеонтологи, Геологийн хүрээлэнгийн судлаачидтай хамтран ажиллаж 2016 оны наймдугаар сарын 21-нд Монголын говь нутгаас үлэмж том хэмжээтэй үлэг гүрвэлийн мөрийг илрүүлсэн байна. Мөрний хэмжээ нь өргөнөөрөө 106 см байгаа ба 100-аас дээш сантиметр хэмжээтэй мөр олох нь ховорт тооцогддог аж. Мөрийг Цэрдийн галав буюу 70-90 сая жилийн өмнө тооцогдох геологийн настай газрын давхаргаас олсон байна.



19. Тухайн олдвор нь Монгол орны ямар аймгаас олдсон байх боломжтой вэ?
- A. Баянхонгор
 - B. Увс
 - C. Өмнөговь
 - D. Завхан
20. Чулуужсан олдворыг ашиглан доорх хүснэгтэд үзүүлсэн үлэг гүрвэлийн шинжүүдийг таамаглаж болох уу? Боломжтой байх 2 хувилбарыг сонгоорой.

№	Таамаглал
1	Үлэг гүрвэлийн үр төлийн тоо хэмжээ, идэш тэжээлийг мэдэж болно.
2	Мөрний байдлаас тухайн үлэг гүрвэлийг яаж алхдаг байсныг мэдэж болно.
3	Үлэг гүрвэлийг аль эрин үед амьдарч байсныг мэдэж болно.
4	Үлэг гүрвэлийн амьсгалын тогтолцоо, хэрхэн устан зэргийг мэдэж болно.

A. 1 ба 2

B. 2 ба 3

C. 2 ба 4

D. 3 ба 4